

АШУУИС

2021.04.23 / №258

Online magazine **МЭДЭЭ**

АГУУЛГА

2 Нүүрт
АШУУИС-ийн ОЮУТНЫ ХИМИЙН ХХИ ОЛИМПИАД ЦАХИМААР АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

4 Нүүрт
“ЭРДМИЙН ЧУУЛГАН-63” АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН САЛБАР ХУРАЛДААНЫ ШИЛДЭГ ИЛТГЭЛҮҮД ТОДОРЛОО

6 Нүүрт
АШУУИС-ийн ЭРДМИЙН ЧУУЛГАН-63 НАС-ЫН САЛБАР ХУРАЛДААН

8 Нүүрт
ЭРДЭМ СУДЛАЛ-2021

12 Нүүрт
“ЭРДМИЙН ЧУУЛГАН-63” БИО-АНАГААХЫН САЛБАР ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

16 Нүүрт
“АЛЬТЕРНАТИВ АНАГААХ УХААН БА ЗҮҮ, ТӨӨНӨ ЭМЧИЛГЭЭ” СЭДЭВТ ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО.

18 Нүүрт
“ МЭДЛЭГЭЭ ТЭЛЭХҮЙ ” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АНХДУГААР ЦАХИМ ХУРАЛ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.



Эрдэм судлал 2021

4 Нүүрт

АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн “Эрдэм Судлал-2021” багш, судлаачдын эрдэм шинжилгээний хурлыг 2021 оны 4-р сарын 7-ны өдөр танхимаар болон цахимаар хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулж нийт 60 орчим багш, судлаачид оролцов



“ЭРДМИЙН ЧУУЛГАН-63” БИО-АНАГААХЫН САЛБАР ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

12 Нүүрт

“Эрдмийн чуулган-63” Био-Анагаахын салбар хуралдаан 2021 оны 4 сарын 9-нд цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулагдлаа. Хуралдааныг нээж Био-Анагаахын Сургуулийн захирал АУ-ы доктор Г.Дарамбазар нийт оролцогч, эрдэмтэн багш, судлаач нартаа



“ Мэдлэгээ тэлэхүй ” эрдэм шинжилгээний анхдугаар цахим хурал амжилттай зохион байгууллаа.

18 Нүүрт

АШУУИС-ийн Анагаах Ухааны сургуулийн Цус судлалын тэнхим, “Ардын эмч Ч.Цэрэннадмид” сангаас хамтран “Монголын Цусны эмгэг судлалыг үүсгэн байгуулагч, Эрүүлийг хамгаалах яамны сайд асан, Монгол Улсын Ардын эмч, Эрүүлийг хамгаалахын гавьяат

АШУҮИС-ИЙН ОЮУТАН ОЛОН УЛСЫН ОЮУТНЫ АНХДУГААР ОНЛАЙН ЧУУЛГАНД ИЛТГЭЛЭЭ ТАНИЛЦУУЛАВ.

2021 оны 4-р сарын 7-ны өдөр Дэлхийн эрүүл мэндийн өдрөөр Олон улсын оюутны Анхдугаар эрдэм шинжилгээний онлайн бага хурал болов. Энэхүү арга хэмжээг Польшийн оюутны эрдэм шинжилгээний байгууллага Life4U болон Быдгоц дахь Эдийн засгийн их сургуулийн Спорт, биеийн тамирын дээд сургууль, Өвөр байгалийн их сургуулийн Инклюзив боловсролын бүсийн төв хамтран зохион байгуулав.

Энэхүү хурал нь сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн эрүүл мэнд, боловсролын асуудлыг өргөн хүрээнд авч хэлэлцэв. Евразийн орнуудаас ОХУ, Польш, Монгол, Киргиз, Украин, Казахстан, Чех, Беларусь зэрэг 12 их сургуулийн оюутан сурагчид оролцон илтгэл тавилаа.

Чуулганд оролцогчдын илтгэлийг Польшийн Быдгоц дахь Эдийн засгийн их сургуулийн Спорт, биеийн тамирын дээд сургуулийн захирал, профессор Александр Скали, WSG-ийн зочин профессор, Өвөр байгалийн их сургуулийн Инклюзив боловсролын бүсийн төвийн захирал Сергей Кохан, оюутны Life4U эрдэм шинжилгээний байгууллагын дарга Ксения Верешчак нар хүлээн авч удирдан явуулав.

